



**НИЙСЛЭЛИЙН  
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ  
ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2014 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 14/173

Улаанбаатар хот

Ажлын хариуцлага, албаны үйл ажиллагааг  
сайжруулах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулах, албаны үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах зорилгоор ДААЛГАХ нь:

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуулийн дагуу явуулахыг шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай. Үүнд:

1.1 Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа төлбөр төлөгчийн өмчлөл, эзэмшилд бүртгэлтэй хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг төлбөрийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжилж, эрхийг хязгаарлах.

1.2 Төлбөр төлөгчийн өмчлөл, эзэмшилд эд хөрөнгө байгаа эсэх талаарх лавлагааг холбогдох газарт хүргүүлэхдээ төлбөр төлөгчийн овог нэр, регистрийн дугаар, хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн дугаарыг үнэн зөв бичиж, нягтлан шалгаж байх.

1.3 Төлбөр төлөгчийн өмчлөл, эзэмшилд эд хөрөнгө байгаа эсэх талаарх лавлагааг холбогдох газарт хүргүүлэхдээ нэр бүхий 5 хүртэлх төлбөр төлөгчийн нэрийг А5 хэмжээний албан тоот дээр бичиж явуулж байх. Тухайн газраас ирүүлсэн лавлагааны хариуг тухай бүр хувилж, гүйцэтгэх баримт бичигт баяжилт хийх.

1.4 Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон /албаны дансанд төлбөрийн мөнгө төвлөрсөн даруйд/ болон гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаасан, харьяаллын дагуу шилжүүлсэн тухай бүрт бүртгэлийн нэгдсэн системд холбогдох тэмдэглэгээг хийлгэж байх.

1.5 Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон даруйд төлбөр төлөгчийн талаарх хязгаарласан хилийн хаалт, үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээн харилцах банкны дансны зарлагын гүйлгээг нээсэн тухай мэдэгдлийг холбогдох газарт хүргүүлж, гүйцэтгэх баримт бичгийг архивт шилжүүлж байх.

1.6 Баримт бичиг боловсруулахдаа албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримталж, монгол хэлний зөв бичих, найруулга зүйн дүрмийн алдаагүй бичиж хэвших.

2. Нийт шийдвэр гүйцэтгэгч нарын шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, зөвтгөн ажиллахыг ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөв зохион байгуулаагүйгээс төлбөр авагч, төлөгч, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлж, хариуцлага тооцох болохыг анхааруулсугай.

4. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга /дэд хурандаа Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ХУРАНДАА



Э. БАТБАЯР